



ХЭНТИЙ АЙМАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 6/84

Чингис хот

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 заалт, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, "Төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 4.1, 4.2 дахь заалтын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тусламжийн албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, Эх нярайн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, Сувилахуй, хөнгөвчлөх, сэргээн засах, настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр, Эмийн чанар аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар, Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ болон оношилгоо эмчилгээний технологи, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, эмнэлгээс шалтгаалсан халдвар хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг зургадугаар, Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг долдугаар, Нийгмийн эрүүл төвийн нөхөн үржихүй, өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг наймдугаар, Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа болон осол гэмтэл, тандалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг есдүгээр, Дархлаажуулалт болон голомтын ариутгал халваргүйтгэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг аравдугаар, БЗДХ-ын болон сүрьеэгийн тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван нэгдүгээр, Эдийн засаг удирдлага төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг арван хоёрдугаар, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арван гуравдугаар, Архив, бичиг хэргийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арван дөрөвдүгээр, Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн

эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн сан хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арван тавдугаар, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арван зургадугаар, Хавдрын эрт илрүүлэг тандалт хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг арван долдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан тушаалын тушаалын тодорхойлолтын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3. Албан тушаалын тодорхойлолт тус бүрийг дагаж мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн /Т.Байгалсүрэн /-д даалгасугай.

ДАРГА



Л. МЭНДБАЯР